



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2024 04 19 № 01/6979
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, гааль, цагдаа, эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн, судлаач нартай хамтран "Нийтийн эзэмшлийн зам талбайд ашиглагдаж буй тусгай зориулалтын бодис" асуудал, шийдэл: "Авлигын эрсдэл, хор уршиг, хүний эрүүл мэнд" сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан.

Уг хэлэлцүүлгээр химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдах, ашиглах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж байгууллагууд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд давс, бодис нийлүүлдэг, түүнд мэргэжлийн байгууллагын хяналт сул байгаагаас хүн байгальд сөрөг нөлөө үзүүлэх, худалдан авагч тал зохих стандарт, аргачлалын дагуу хэрэглэхгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй захиран зарцуулдаг асуудлууд байх тул авлигын гэмт хэрэг, зөрчил үүсэх нөхцөлийг бүрэн арилгуулахаар албан зөвлөмжийг Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасны дагуу хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар тухай бүр хариуг ирүүлнэ үү.


Хувийг: Нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-т.

Хавсралт 4 хуудас

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР

З.ДАШДАВАА

Авлигатай тэмцэх газрын даргын
2024 оны 04 дүгээр сарын 19-ны
өдрийн 01 дугаар албан
бичгийн хавсралт



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Нийтийн эзэмшлийн зам талбайд ашиглагдаж буй тусгай зориулалтын давс, бодисыг ашиглахад олон улсын туршлагыг судлах, агаарын температурын хэлбэлзэлд тохируулан давс, бодисын харьцааг температурын хязгаартай уялдуулан сонгож хэрэглэдэг болох;

Нийслэлийн хэмжээнд нийт 14 давс, бодис цацах зориулалтын машин байдаг ба -15°C температур хүртэл хүйтэнд давсыг хатуу хэлбэрээр гүүр, уулзвар, эргэлттэй замын дагуу цацдаг, -15°C температураас дээш хүйтэнд давсыг хатуу хэлбэрээр цацан цасыг хайлуулж чаддаггүй байна.

Өмнөх жилүүдэд ОХУ-аас -15°C -ээс -30°C температурын хооронд ашиглах бодис худалдан авч цас, мөсийг хайлуулж байсан бол -30°C температураас дээш хэмийн хүйтэнд дээрх бодис халтиргаа, гулгааг хайлах боломжгүй байв. Иймд 2024 оны эхээр Хятад улсаас -30°C температураас дээш хэмийн хүйтэнд цас, мөс хайлуулах чадвартай бодис авч, хэт их хүйтрэхээр элс, хайрга, дайргатай хамт цацах туршилтууд хийжээ.

Олон улсын туршлагаар зам талбайн халтиргаа гулгааг хайлуулахад давсыг шууд цацвал цастай холилдож гулгааг хайлуулахгүй, шингэлт байхгүй, харин давсыг устай хольж уусмал бэлдэж цацвал халтиргаа гулгааг хайлуулах чадвар нь илүү нэмэгдэж, $^{\circ}\text{C}$ температурт хөлдөхгүй, тэсвэртэй байх чанар дээшилдэг.

Уусмал бэлдэх цехтэй, давс болон уусмалаа хадгалах зориулалтын агуулахтай, замын дулааныг хэмждэг хэмжилт хийдэг багажтай /аль замын хэсгээр хүйтэрч байгаа эсэхээс хамаарч давсны хэмжээг тохируулдаг/, агаарын температур, агаарын чийгшил, замын хөдөлгөөний мэдээлэл, үрэлт зэргийг Замын хөгжлийн газар судлан хэмжиж тогтоож, уусмалыг цацдаг байна. Мөн энэ чиглэлээр албан тушаалтнуудыг сургах, мэдээлэл өгөх ажлуудыг тогтмол зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангасан байдаг.

Хэлэлцүүлгээр Монгол Улсын Шинжлэх ухааны академийн хими, химийн технологийн хүрээлэнгийн Экологийн химийн лабораторийн доктор Рн О.Хүрэлдаваа, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн химийн тэнхим дэд профессор доктор Д.Илчгэрэл нар урилгаар оролцон, шинжлэх ухааны үүднээс дэлгэрэнгүй зөвлөгөө өгсөн. Тэдний үзэж байгаагаар давс, бодисын найрлагад хүнсний давс, магни хлорид, кальци хлорид, хүхэр хүчлийн магнийн давс, сульфат кальци, кальцийн гидро карбонат, кальцийн карбонат болон усанд үл уусах бодис агуулагддаг.

Үйлдвэр бүр цас хайлуулах бодисын найрлагыг өөр өөрөөр хийдэг ч ерөнхийдөө химийн эдгээр бодис их, бага ямар нэг хэмжээгээр агуулдаг. Зарим нь натри хлорид түлхүү агуулдаг байхад үндсэн найрлагынх нь 70 хувь нь кальци хлоридоос бүрддэг бодис байна. Үүнээс үзвэл цас хайлуулах бодисыг төрөл бүрийн давснаас бүрддэг гэж үзэж болно. Иймд дараах байдлаар цас их орсон үед давс, бодисыг ашиглах нь зүйтэй. Үүнд:

Натрийн хлоридын 23.3%-ийн уусмалын онолын хөлдөх температур -21°C байдаг бол кальцийн хлоридын 29.6%-ийн уусмалын онолын хөлдөх температур -

510C байдаг. Энэ нь натрийн хлоридыг 23.3%-иар цастай холивол онолын хөлдөх температур -210C байдаг бол кальцийн хлоридыг цастай 29.6%-иар холивол онолын хөлдөх температур -510C байна. Тэдгээрийн концентраци буурахад хөлдөх температур нь буурч байдаг, өөрөөр хэлбэл цасыг хайлуулах чадвар нь буурч байдаг. Хөрсний температур -100C-ийн үед байвал зөвхөн натрийн хлоридоор цасыг хайлуулж болно, түүнээс илүү хүйтэн үед /*онолын температур бодит байдалд багасаж ирдэг*/ кальцийн хлоридтой хольж ашиглах нь илүү үр дүнтэйгээс гадна бас эдийн засгийн талаасаа ашигтай байх болно. Жишээлбэл -150C-ийн үед NaCl:CaCl₂ харьцааг 2:1, -200C-ийн үед NaCl:CaCl₂ харьцааг 1:1, -250C-ийн үед NaCl:CaCl₂ харьцааг 1:2, -300C-ийн үед зөвхөн CaCl₂ гэх мэтээр ашиглавал зохимжтой.

Энэ нь зөвхөн онолын баримжаалсан тооцоо бөгөөд нарийвчилсан тооцоог хийхийн тулд туршилт хийх шаардлагатай. /*хамтарсан туршилт хийхэд Монгол Улсын Шинжлэх ухааны академи, ШУТИС-ын химийн тэнхимтэй хамтран ажиллах*/ Дээрх өгүүлсэн температурыуд 5°C-ээр буурах магадлалтай тул дээрх харьцаа тоонууд хэлбэлзэх боломжтой байдаг байна.

Зөвлөмж 2. Цас, мөс цэвэрлэх аргачлал, стандартыг олон улсын жишиг болон авто замын барилга, байгууламжийн дэд бүтэцтэй уялдуулан боловсруулж батлуулах, нийслэлийн төвийн 9 дүүрэгт нэвтрүүлэх, мөрдүүлэх;

Нийтийн эзэмшлийн зам, талбайд ашиглагдаж буй тусгай зориулалтын давс, бодис цацахтай холбоотой аргачлал, стандарт одоог хүртэл батлагдаагүй байна.

Өнөөдрийг хүртэл цаг агаарын нөхцөл байдлаас хамаарч замын гулгаатай зарим хэсгүүдэд давс, бодис цацаж байгаа нь олон улсын туршлага судлахгүй, судалгаа, дүн шинжилгээ хийгээгүй, бодисыг найруулах цех байргүй, замын дулаан хэмждэг багаж, төхөөрөмжгүй, давс цацах технологийн дэвшилтийг ашиглахгүй байгаа нь учир дутагдалтай гэх дүгнэлтэд хүрсэн.

Иймд цас, мөс цэвэрлэх аргачлал, стандартыг олон улсын жишиг болон нийслэл хотын нөхцөл байдалтай уялдуулан баталж мөрдүүлэх.

Нийслэлийн хотын стандарт, хяналтын газраас авсан судалгаагаар 2024 онд 20 гаруй стандартыг баталж мөрдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд уг жагсаалтад авто замын байгууламжийн халтиргаа гулгааг арилгахад давс, бодис ашиглахтай холбоотой стандартын төсөл, санал ирээгүй байгаа тул бодлого төлөвлөлтийг хийж буй Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба үүнд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Одоогийн байдлаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/87 дугаартай Нийслэлийн хотын стандарт, хяналтын газарт “Хот тохижилтын салбарын зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах шаардлага, нэгдсэн аргачлал, стандартыг боловсруулж хамтран ажиллах” тухай албан бичиг хүргүүлсэн хэдий ч цас, мөс цэвэрлэх аргачлал, стандартын төслийг хүргүүлээгүй байна.

Зөвлөмж 3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам, талбайг цэвэрлэх үүргийг хэрэгжүүлэхэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажил зохион байгуулж, үр дүнг тухай бүр тооцох;

Халтиргаа, гулгаанаас сэргийлсэн нэгдсэн төлөвлөгөө, ажлын зураглал байхгүйгээс цаг агаарын үзэгдлээс сэргийлэх хариу арга хэмжээ авах бэлэн байдал хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, дүүрэгт харьяалагдах төр, хувийн хэвшлийн байгууллагуудаар цас, мөс цэвэрлүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилладаг болох, халтиргаа гулгаа ихэссэн тухай бүрд нийтийн

эзэмшлийн талбайд давс, бодис цацах ба тухайн хэсгийн цас хайлах үед цэвэрлэгээг тухай бүрд хийх, оршин суугаа хотхоны СӨХ-ийн үйл ажиллагаанд цас, мөс болон гадна талбайн цэвэрлэгээг чухалчлан үзэж тухайн хорооны хяналтыг сайжруулах, байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах болон үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгоход 50-100 метр доторх гадна талбай, замын тохижилт болон цас мөс цэвэрлэгээ зэргийг хариуцахыг үндсэн шалгуурт оруулж өгөх зэрэг ажлыг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах шаардлагатай гэж хэлэлцүүлэгт оролцогч нарын зүгээс дүгнэсэн.

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр доторх нийтийн эзэмшлийн зам талбайд ногоон байгууламж байгуулах, арчилгаа цэвэрлэгээг хариуцаж, өвлийн улиралд хүн томилж цас, мөсийг тухай бүрд нь арилгаж, халтиргаа гулгаа үүсгэлгүйгээр, иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байдаг тул хэрэгжилтийг ханган ажиллаж, хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.12-т *“нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох”*-ыг сум, дүүргийн Засаг дарга нар, 10 дугаар зүйлийн 10.2.10-т *“энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх”* үүргийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, мөн Зөрчлийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3-т зааснаар *“оршин байгаа газартаа хамаарах замын бохирдол, цас, мөсийг цэвэрлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”* гэснийг хэрэгжүүлбэл нийтийн эзэмшлийн гудамж, талбайн халтиргаа гулгааг арилгаж, иргэдийн амь нас, эрүүл мэнд, төсвийн зарцуулалтыг хэмнэх боломжтой байна.

Зөвлөмж 4. Замын цас, мөс хайлуулах, арилгахад ашиглаж буй техник хэрэгслүүдийг шинэчлэх, сайжруулах, цас, мөс цэвэрлэх тоног төхөөрөмжийн судалгаа хийж, санхүүжилтийг шийдвэрлэх;

Цас, мөс цэвэрлэх тоног төхөөрөмжийн судалгааг Нийслэлийн 9 дүүрэгт хийж, төсөвт суулган худалдан авалт хийснээр хүний оролцоо багасах, техник технологийн дэвшилтэд бүхий тоног төхөөрөмжийг ашиглан түргэн шуурхай, үр дүнтэй, бүтээмжтэй ажиллах, төсвийн хөрөнгийг хэмнэх боломжтой юм. Тухайлбал, зарим дүүргүүдээс техник, тоног төхөөрөмжийн судалгаа авахад:

1. Сүхбаатар дүүрэг оны эхээр универсал трактор-1, бобкат машин-1, том оврын ковш машин-2 ширхгийг тус тус худалдан авсан, дүүргийн хэмжээнд зам талбайн цэвэрлэгч, хог тээвэрлэлтийн ажилтнууд 400 орчим ажиллаж байна. Нийт 20 хороонд усалгааны 3 машин 10-15 тн /*ашиглалт, зориулалт нь халдваргүйжүүлэлт, ариутгал, бодис цацаж болно*/, зам цэвэрлэгээний 20 гаруй машин хэрэгтэй;
2. Налайх дүүргийн хэмжээнд 2024 онд цас, мөс цэвэрлэх тоног төхөөрөмж худалдан аваагүй, гар аргаар хусаж цэвэрлэдэг, одоогоор давс цацдаг 1 машинтай. Цаашид шаардлагатай автогрейдер машин-1 ширхэг, цас түрдэг, угаадаг, цэвэрлэдэг машин-2 ширхэг, давс цацдаг машин-2 ширхэг, задгай тэвштэй тээврийн хэрэгсэл /*өөрөө буулгагч машин*-6 ширхэг хэрэгтэй;
3. Баянгол дүүрэгт одоогийн байдлаар хог ачдаг машин 31 ширхэг, давс цацдаг машин 2 ширхэг, 1 ковштой, 1 автогрейдер машинтай, 1 зам талбайн шүүрдэгчтэй байна. Цаашид зам угаадаг машин-3 ширхэг, давс цацдаг машин 2 ширхэг, бобкат машин-2 ширхэг, ковш машин-1 ширхэг тус тус хэрэгтэй;

4. Хан-Уул дүүргийн хэмжээнд давс, бодис цацах олон үйлдэлт машин-3 ширхэг, зам түрэх, шүүрдэх, услах, соруулах үйлдэлтэй машин-3 ширхэг, явган замын цас шүүрддэг түрдэг төхөөрөмж-10 ширхэг, явган замын үүрдэг цас үлээгч-10 ширхэг, авто ачигч-2 ширхэг, задгай тэвштэй авто машин-4 ширхэг, 50 ковш-1 ширхэг, 4 дугуйтай экскаватор-1 ширхэг, цасны төхөөрөмж үүрэх-2 ширхэг, замын хог, цас тээвэрлэх-2 ширхэг, 4 үйлдэлт ковш-2 ширхэг, бобкат-1 ширхэг, цацагч-4 ширхэг, цэвэрлэгээний машин-5 ширхэг, самосвол-1 ширхэг, автогрейдер-1 ширхэг, бензин хөдөлгүүрт үүрдэг үлээгч-5 ширхэг, хусагч-5 ширхэг, 939 ковш-1 ширхэг, түрэгчтэй универсал ковш-1 ширхэг, задгай машин-2 ширхэг тус тус авахаар төлөвлөсөн. Цаашид 4 дугуйтай экскаватор-1 ширхэг, 4 үйлдэлт ковш-6 ширхэг хэрэгтэй;
5. Баянзүрх дүүрэгт “Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын авто баазын авто болон өөрөө явагч тээврийн хэрэгсэл, машин механизмын бүртгэлээр 43 техник хэрэгсэл байгаа боловч, дүүргийн хэмжээнд хүрэлцээгүй, цаашид автогрейдер-5 ширхэг, зам цэвэрлэх, шүүрдэх, услах, соруулах үйлдэлтэй машин-10 ширхэг, өрөө буулгагч том оврын 15-20 тонн машин-10 ширхэг, автозам угаагч том оврын машин-5 ширхэг, экскаватор 140 дугуйт-1 ширхэг, ачигч буулгагч-3 ширхэг, цас хусах, ачих машин-3 ширхэг, зам цэвэрлэгээний бичил машин-10 ширхэг тус тус хэрэгтэй;
6. Чингэлтэй дүүрэгт тохижилт хариуцсан 2 компаниар цэвэрлэгээ үйлчилгээ, давс, бодис цацуулдаг бөгөөд улсад бүртгэлтэй задгай тэвштэй-13 машин байдаг. Цаашид давс, бодис цацдаг машин-2, хусагч машин-2, зам талбай шүүрдэгч машин-2 тус тус хэрэгтэй;
7. Сонгинохайрхан дүүрэгт 1 тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ, 7 хувийн хэвшлийн компани байдаг бөгөөд эдгээр байгууллагууд нь тоног төхөөрөмжийн хувьд тааруу байдаг, өнөөдрийн байдлаар зам цэвэрлэгээний машин-6 ширхэг, зам цэвэрлэгээний мини төхөөрөмж-30 ширхэг, давс, бодис цацдаг тусгай зориулалтын машин-7, бобкат машин-14 ширхэг, ачааны ковш-1 ширхэг тус тус зайлшгүй хэрэгтэй байгаа талаарх мэдээллийг бидэнд ирүүлсэн.

Цаашид Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь нэгдсэн бодлогоор дүүргүүдийн тоног төхөөрөмжийг сайжруулах, нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Зөвлөмж 5. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” аваагүй аж ахуйн нэгжээс цас, мөс хайлуулах бодис худалдан авч байгааг таслан зогсоож, хил гаалийн бүрдүүлэлттэй эсэхийг нягтлан үзэж, ил тод нээлттэй сонгон шалгаруулалтаар худалдан авах;


Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд сүүлийн 3 жил давс, бодис нийлүүлсэн “Мөнх сонор” ХХК, “Койн хаус” ХХК, “Масс теч” ХХК, “Гадаад даян” ХХК, “Амето” ХХК, “Дабльхас” ХХК-иуд нийтийн эзэмшлийн зам, талбайд ашиглах тусгай зориулалтын химийн бодисыг хилээр нэвтрүүлэхдээ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын 2009 оны 334/104 дугаартай хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”-ын дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгай зөвшөөрөл авах ёстой байтал аваагүй бараа материал нийлүүлсэн байна.

Иймд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2022-2024 онуудад давс, бодис нийлүүлсэн худалдан авах ажиллагаанд шалгарсан 6 компанид дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдсон.

Тендер худалдан авах ажиллагаагаар 2022 онд “Мөнх сонор” ХХК, 2023 онд “Койн хаус” ХХК, 2024 онд “Масс теч” ХХК, “Гадаад даян” ХХК, “Амето” ХХК, “Дабльхас” ХХК-иуд шалгарч, тус компаниудын гаалийн статистик мэдээлэлд шүүлт хийхэд аж ахуйн нэгж бүрээр мэдүүлсэн нэр дээр албан ёсны “цас хайлуулах” гэдэг нэрээр бараа материалыг мэдүүлээгүй. Тухайлбал,

- “Масс теч” ХХК, “Дабльхас констракшн” ХХК нар нь “давс, бодис” гэдэг нэрээр улсын хэлээр бараа материал нэвтрүүлээгүй, бүрдүүлэлт хийгдээгүй, бараа импортлоогүй. Гэтэл Нийслэлийн захирагчийн ажлын албанаас 2023-2024 онд “Масс теч” ХХК-400 тн, “Дабль хас” ХХК-400 тн-ыг тус тус нийлүүлсэн. “Масс теч” ХХК нь дээрх онуудад нийт 112 бүрдүүлэлт хийсэн ч огт давс, бодис сүүлийн 5 жилд оруулаагүй;
- “Дабльхас констракшн” ХХК нь 2020-2021, 2023-2024 онд хилээр бараа материал огт нэвтрүүлээгүй;
- “Койн хаус” ХХК 2023 онд ямар ч бүрдүүлэлт хийгдээгүй, гаалиар бараа, материал импорт хийгдээгүй байтал 2023 онд Нийслэлийн Захирагчийн ажлын албанд 2700тн бодис нийлүүлсэн. /ОХУ/;
- “Мөнх сонор” ХХК нь 2022 онд 25110\$ үнэ бүхий давс нэрээр хилээр оруулсан. /ОХУ/ Нийслэлийн Захирагчийн ажлын алба 2022 онд 1000 тн давсыг тус компаниас нийлүүлсэн;
- “Гадаад даян” ХХК нь 2023 онд Нийслэлийн Захирагчийн албанд бодис нийлүүлсэн гэх боловч хилээр ямар ч бараа материал нийлүүлээгүй. 400тн давсыг худалдан авсан байна. Харин БНХАУ-ын Weifang Haizgiyuan Chemistryand industry Co.,Ltd-ээс 2024 онд 3 удаагийн бүрдүүлэлт хийсэн ба 1 дүгээр сарын 9, 1 дүгээр сарын 12, 1 дүгээр сарын 29-ний өдрүүдэд хилээр 78042,635\$ давсыг нэвтрүүлсэн;
- “Амето” ХХК нь 2023 онд Нийслэлийн Захирагчийн албанд бодис нийлүүлсэн гэх боловч ямар ч бүрдүүлэлт хийгдээгүй, бараа материал оруулаагүй. Нийслэлийн Захирагчийн албанаас тус компанитай 400 тн давсыг худалдан авсан. /БНХАУ-ын Weifang Haizgiyuan Chemistryand industry Co.,Ltd-ээс 2024 онд 7 удаагийн бүрдүүлэлтээр 27885,249\$ давсыг хилээр оруулсан. /1 дүгээр сарын 13-нд 2 удаа, 1 дүгээр сарын 14, 1 дүгээр сарын 16, 1 дүгээр сарын 18-нд 2 удаа, 1 дүгээр сарын 20-нд тус тус хилээр нэвтэрч бүрдүүлэлт хийсэн/.

Дээрх нөхцөл байдлыг дүгнэхэд “давс” “бодис” нэрээр хилээр бараа материал огт оруулж ирээгүй “Масс теч” ХХК, “Дабльхас констракшн” ХХК компаниудыг тендерт шалгаруулсан, тендерт шалгарсан гэх компаниудын тендерт оролцсон мэдээллийг харахад “давс” “бодис” нийлүүлэх чиглэлээр оролцоогүй “Масс теч” ХХК, “Гадаад даян” ХХК, “Дабльхас констракшн” ХХК-иуд байв. Жил ирэх тусам давс, бодис нийлүүлэлт ихсэж, худалдан авалт их хийгдсэн хэдий ч замын халтиргаа, гулгааны асуудлыг шийдэж чадахгүй иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, төсвийн үргүй зарцуулалт бий болж байгаа нь авлигын гэмт хэрэг үйлдэх нөхцөл бүрдэж байна.



Зөвлөмж 6. Халтиргаа, гулгаанаас үүдэлтэй зам тээврийн ослын судалгаа, иргэдийн гаргаж буй өргөдөл, гомдолд тогтмол дүн шинжилгээ хийн бодлого төлөвлөлтөө сайжруулах;

Сүүлийн жилүүдэд халтиргаа гулгаанаас үүссэн иргэдийн гомдол, мэдээлэл ихсэж байна. Тухайлбал, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 2023 онд 62, 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 39 гомдол мэдээлэл ирсэн байна.

Одоогийн байдлаар халтиргаа гулгааг арилгах цогц шийдэл ажлын аргачлал байхгүй, Нийслэлийн хотын авто замын хэмжээ нэмэгдсэн, энэ жил өмнөх жилүүдээс илүү хурд тунадас орж хүйтэрсэн, бэлтгэл ажил хангаагүй, техник хэрэгсэл дутагдалтай, төрийн байгууллагын уялдаа холбоогүйгээс цас цэвэрлэх, арилгах ажлыг тухай бүр хийдэггүй, зарим газрыг орхигдуулдаг учраас иргэд, олон нийтийн зүгээс бухимдалтай хандаж байна.

Гэмтэл согог судлалын үндэсний төвөөс авсан судалгаагаар Нийслэлд цас мөсөн дээр халтирч унасан тохиолдлын хамгийн их хувь буюу 19.1% нь Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт байгаа бол Баянзүрх дүүрэг 18.8%, Сонгинохайрхан дүүрэг 18.5%, Хан-Уул дүүрэг 13.0%, Сүхбаатар 10.2%, Чингэлтэй дүүрэг 8.4%, Налайх дүүрэг 0.4%, Багануур болон Багахангай дүүрэг 0.1%-ийг тус тус эзэлж байна. Үлдсэн хувь нь хөдөө орон нутагт гэмтээд нийслэлийн эмнэлгүүдээс тусламж үйлчилгээ авчээ.

Зам тээврийн ослын 2022-2023 оны судалгаагаар суудлын машин дотор явж байгаад гэмтэх нь түгээмэл байна. Тухайлбал, суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 37%, явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 29.3%, мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 10.2%, ердийн

хөсгийн осол 10.2%, дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 8.7%-ийг тус тус эзэлж байна.

Нийслэлд бүртгэгдсэн зам тээврийн ослын 35.0% хөдөө орон нутгийн замд осолд ороод нийслэлийн эмнэлгээс ирж тусламж үйлчилгээ авсан байгаа бол үлдсэн тохиолдлын 16.5% Баянзүрх дүүрэг, 14.3% Хан-Уул дүүрэг, 13.9% Сонгинохайрхан дүүрэг, 12.6% Баянгол дүүрэг, 7.5% Сүхбаатар дүүрэг, 6.5% Чингэлтэй дүүрэг, 2.4% Налайх дүүрэг, 0.7% болон 0.5% Багануур болон Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт тохиолджээ.

Дээрх судалгаанаас харахад Нийслэлд цас мөсөн дээр халтирч унасан тохиолдлын хамгийн их хувь Баянгол дүүрэг, зам тээврийн осол Баянзүрх дүүрэгт ихээхэн тохиолдож байгаад анхаарал хандуулан тус дүүргүүдийн зам, талбайд давс, бодисыг түлхүү цацах нь бодитой үр дүнтэй ажил болох юм.

Зөвлөмж 7. Замын цас хайлуулах давс, бодис цацсан цасыг ногоон байгууламж руу хаяхгүй, цацахгүй байхад анхаарах, нэгдсэн стандартад тусгах, албан тушаалтнуудад анхааруулах, давс, бодистой цасыг гол, горхи зэрэг ундны усанд оруулахаас сэргийлж тусгай цэгт асгадаг болох;

Нийслэлийн зам талбайд давс, бодис цацсаныг цэвэрлэхдээ ногоон байгууламж руу цацаж, цэвэрлэж байгаа нь байгаль, ногоон ургамалд хортойг химич, биологичид үзэж байна.

Манай улс замын халтиргааг арилгахад сүүлийн 20 жилийн турш давс ашиглаж ээ. Энэхүү бодисыг удаан хугацааны турш ашигласнаар ногоон байгууламж /мод, зүлэг/ сөргөөр нөлөөлдөг бөгөөд нийслэлд хавар болон зуны улиралд жил бүр зүлэгжүүлэлтийг дахин хийж төсвийн хөрөнгийг үр ашиггүй захиран зарцуулахад хүргээд байна.

Хот тохижилтын байгууллагаас 2001 онд Улаанбаатар хотын хэд хэдэн газраас хөрсний дээж авч ОХУ, БНХАУ-д шинжлүүлэхэд *“Танай хөрс чулуулаг, элс ихтэй, хар шороо багатай тул үржил шим тааруу, ийм хөрсөнд элс хольж болохгүй, элс, давстай цасаа ногоон байгууламж руугаа хийгээд байвал зүлэг муу ургаж, тоосжилт улам нэмэгдэнэ”* гэсэн хариу өгсөн байдаг.

Хэлэлцүүлгийн явцад иш, мөчир, навч нь өвөлжин угаарт хордох, үндсээрээ химийн бодист идэгдэхээр мод бут, ногоон байгууламж ургахгүй, мөн тохижилт үйлчилгээний ажилтнуудад бодис, давсыг хэрхэн зааврын дагуу ашиглах талаарх нэгдсэн зааварчилгаа өгч, цэвэрлэгээнээс үүдэлтэй цас, хаягдлыг хүрээлэн буй орчинд хоргүй байдлаар төвлөрсөн нэг цэгт хаях ажлыг зохион байгуулах хэрэгтэй болохыг оролцогчид дүгнэсэн болно.